



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

2023-2024 ОНЫГ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ЖИЛ БОЛГОН ЗАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалтад заасан "хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх", Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан "нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах" бүрэн эрхийнхээ хүрээнд ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын "Засаглал"-ын зорилт, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын "Төрийн бүтээмжийн сэргэлт"-ын зорилтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хөгжлийг боомилон сааруулагч гол хүчин зүйлс болох авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж, авлига, хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, үл тэвчих хандлагыг олон нийтийн дэмжлэг, оролцоотойгоор төлөвшүүлэн бүх шатанд авлигыг таслан зогсоосны үндсэн дээр хүний эрхийг ханган нийтийн эрх ашгийг хамгаалж, хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласугай.
2. Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан энэ тогтоолын хавсралтаар баталсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тогтсугай.
3. Авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлэх авлигатай тэмцэх ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллахыг иргэд, олон нийтэд уриалсугай.
5. Авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажиллагаа, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, холбогдох санхүүжилтийг шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, салбар дундын уялдааг хангаж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт тус тус даалгасугай.
6. Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах, хамтарсан ажлын хэсэг байгуулах, шаардлагатай хүний нөөцийг татан оролцуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН